

Golomt Capital®

ДЭЛХИЙН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ

2025.02.03

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ


ТОВЧ

- DeepSeek шинэ AI загвараа танилцуулснаар технологийн салбарт өрсөлдөөнийг нэмэгдүүлэв.
- NVIDIA-ийн хувьцаа 17%-иар унасан нь DeepSeek-ийн бага чип ашиглалттай холбоотой байв.
- АНУ-ын Төв банк бодлогын хүүг 4.25%-4.50% дээр хадгалахаар шийдвэрлэв.
- Хятадын PMI индекс 50-с бага буюу агшилтын бүсэд шилжиж, АНУ-ын тариф нэмэгдэх эрсдэл өндөр хэвээр байна.
- Alibaba-ийн хувьцаа өсөхөд тус компанийн шинэ хиймэл оюун ухааны загвар болох Qwen2.5-Мах-ийн дэлгэрэнгүй мэдээлэл танилцуулсан нь голлон нөлөөлөв.

S&P 500 индексийн
2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
Дундаж	6,678

График 1. Өнгөрсөн долоо хоногт хөрөнгийн зах зээлд өрнөсөн голлох үйл явдлууд





АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.01.27-02.02

DEERSEEK ЗАХ ЗЭЭЛИЙГ 2 ХОНОГ Л ШУУГИУЛАВ



Өнгөрсөн долоо хоногт хөрөнгө оруулагчдын анхааралын төвд байсан гол сэдэв **DeepSeek нэртэй Хятадын хиймэл оюун ухаан хөгжүүлэгч** байгууллага шинэ хиймэл оюун ухааны загварыг танилцуулсан явдал байлаа.

- Шинэ загварын онцлог: DeepSeek-ийн танилцуулсан загвар нь бусад тэргүүлэгч хиймэл оюун ухааны програмуудаас эрчим хүчний зарцуулалт илүү бага боловч мэдээллийг боловсруулах чадвар ижил түвшинд байсан нь анхаарал татлаа.
- Эрсдэл ба өрсөлдөөн: Тус шинэ технологи нь дэлхийн хиймэл оюун ухааны зах зээлд өрсөлдөөн үүсгэж, АНУ-ын технологийн хувьцаануудыг унахад хүргэсэн. Гэхдээ энэхүү үйл явдлыг АНУ-ын ерөнхийлөгч Доналд Трамп “манай компаниудад өгч байгаа эерэг сануулга боллоо” хэмээн дүгнэлээ.
- Зах зээлд үзүүлсэн нөлөө: Энэхүү үйл явдлын шууд нөлөө нь өнгөрөгч Даваа гарагт тод илэрч, NVIDIA-ийн хувьцааны ханш ойролцоогоор 17%-иар унажээ. Учир нь Deepseek бусад хиймэл оюун ухааны загвар хөгжүүлэгч нараас бага тооны Nvidia-гийн чип хэрэглэсэн нь ирээдүйд тус компанийн борлуулалт буурна гэсэн айдсыг зах зээлд төрүүлжээ.

APPLE, META ТАЙЛАН САЙН ГАРСНААР ХҮЛЭЭЛТ ИХСЭВ



S&P 500-ийн зах зээлийн үнэлгээний ойролцоогоор 40%-ийг төлөөлж буй томоохон компаниуд тайлангаа танилцуулсан бөгөөд эдгээр тайлан нь зах зээлийг эргэн сэргээхэд чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Тухайлбал, технологийн салбарт **Meta Platforms болон Apple** зэрэг томоохон компаниудын сайн орлогын тайлан болон ирээдүйн урам зоригтой төлөвлөгөө нь зах зээл дээр хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлж, хувьцааны үнийг Дэмжсэн байна.

АНУ-ЫН ХНС ХҮҮГ 4.25%-4.50% -Д ХАДГАЛЛАА



АНУ-ын Холбооны Нөөцийн Сан 2025 оны анхны хурлаа Лхагва гарагт хийж, бодлогын хүүг 4.25%-4.50% түвшинд тогтвортой байлгахад шийдвэрлэснээ зарлав.

Төв банкны хурлын дараах мэдэгдэлд дурдсанаар, АНУ-ын эдийн засгийн үйл ажиллагаа “тогтвортой хурдтайгаар өргөжин тэлсээр” байгаа бөгөөд “хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал тогтвортой хэвээр” байгааг онцолсон. Харин инфляци “бага зэрэг өндөр” түвшинд хадгалагдаж байгааг дурдсан байна.

Хурлын дараах хэвлэлийн бага хурлын үеэр төв банкны дарга Жером Пауэлл “Мөнгөний бодлогыг яаравчлан өөрчлөх шаардлагагүй” гэж мэдэгдсэн бөгөөд бодлогын хүүг дахин бууруулахаас өмнө инфляцид бодит ахиц гарах эсвэл хөдөлмөрийн зах зээл сулрахыг ажиглах шаардлагатай хэмээжээ.



Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.01.27-02.02

ХЯТАДЫН ЗАХ ЗЭЭЛ 2 САРЫН 5-НД НЭЭГДЭНЭ



Хятадын хувьцааны зах зээл баярын улмаас богиносгосон долоо хоногт бага зэрэг бууралттай байлаа. Дотоодын голлох CSI 300 индекс болон Шанхайн нийлмэл индекс Даваа гарагт буюу Сар шинийн баярын өмнөх сүүлийн арилжааны өдөр уналттай хаагдав. Хятадын зах зээл нэгдсэн баярын улмаас нэгдүгээр сарын 28-наас хоёрдугаар сарын 4 хүртэл хаалттай байсан бөгөөд хоёрдугаар сарын 5-нд арилжааг үргэлжлүүлэх юм. Харин Хонг Конг дахь Hang Seng индекс Даваа гарагт бага зэрэг өсөлттэй хаагдсан.

ХЯТАДЫН PMI 50-ААС УНАЖ, АГШИЛТАД ОРЛОО



Даваа гарагт гаргасан засгийн газрын мэдээллээс үзэхэд Хятадын эдийн засаг 2025 оныг сул гараанаас эхлүүлсэн байна. Улсын статистикийн газрын мэдээлснээр, нэгдүгээр сард албан ёсны үйлдвэрлэлийн худалдан авалтын менежерүүдийн индекс (PMI) 49.1 болж, хүлээгдэж байснаас доогуур түвшинд хүрчээ. Үйлдвэрлэлээс бусад салбарын PMI (барилга, үйлчилгээний үйл ажиллагааг хэмждэг) арванхоёрдугаар сарын 52.2-оос 50.2 болж буурсан байна. (Индексийн 50-аас дээш утга нь өсөлтийг, 50-аас доош утга нь агшилтыг илтгэнэ.)

ХЯТАДЫН КОМПАНИУДЫН АШИГ 3.3%-иар БАГАСАВ



Хятадын үйлдвэрлэлийн PMI нь Сар шинийн баярын үеэр сая сая ажилчид төрөлх нутаг руугаа буцдагтай холбоотойгоор нэгдүгээр сард ердийнхөөс сул үзүүлэлттэй гардаг. Гэсэн хэдий ч, Даваа гарагт гаргасан бусад мэдээлэл нь 2024 оны сүүлчээр Хятадын эдийн засаг сул байсныг харууллаа. Томоохон аж үйлдвэрийн компаниудын ашиг 2024 онд 3.3%-иар буурсан бөгөөд энэ нь гурав дахь жилдээ дараалан уналт үзүүлсэн гэсэн үг юм. Эдийн засагчдын үзэж байгаагаар аж үйлдвэрийн ашиг буурсны гол шалтгаан нь инфляцийн дарамт бөгөөд Хятадын эдийн засаг үл хөдлөх хөрөнгийн салбарын олон жилийн хямралын улмаас дотоодын эрэлтийг бууруулсан явдал юм.

ALIBABA-ИЙН QWEN 2.5 НЬ CHATGPT 4.0-ИЙГ ДАВНА




Alibaba-ийн хувьцаа өсөхөд тус компанийн шинэ хиймэл оюун ухааны загвар болох Qwen2.5-Max-ийн дэлгэрэнгүй мэдээлэл танилцуулсан нь голлон нөлөөлөв.

Qwen2.5-Max ба өрсөлдөөн: Alibaba-ийн шинэ загвар нь Arena-Hard, LiveCodeBench зэрэг хэд хэдэн үнэлгээний тест дээр DeepSeek V3-аас илүү гүйцэтгэлтэй гарсан бөгөөд MMLU-Pro зэрэг бусад сорилтуудад өрсөлдөхүйц үр дүн үзүүлжээ.

Alibaba нь уг загварын Qwen Chat платформоор дамжуулан хэрэглэгчид шууд түрших боломжтой болгосон бөгөөд Alibaba Cloud-ын API ашиглан хөгжүүлэгчдэд нээлттэй болгохоор төлөвлөж байна. Энэ алхам нь Alibaba-ийн үүлэн тооцооллын үйлчилгээг өргөжүүлэх стратегийн чухал хэсэг болохыг харуулж байна.

График 2: S&P500 индекст багтах компаниудын 36% нь 4-р улирлын тайлангаа танилцуулжээ



Хүснэгт 1: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E

W

EARNINGS

WHISPERS

Most Anticipated Earnings Releases

for the week beginning

February 03, 2025

Monday

Before Open

After Close

SALA



TSN



Tyson



ALLIANCE



TWIST



IDEX



LVRO



LAVORO



JOHNSON



KYOCERA



MIRAAY



muRata



NSCC



NSAPCO



PLTR



KD



DOC



INCY



NXP



CLX



The Clorox Company



RBB



RBB BANCORP



bellring



fabrinet



RMBUS



FLXS



APOLLO



Tuesday

Before Open

After Close

PYPL



SPOT



PEP



PEPSICO



PFE



REGN



REGENERON



MERCK



AMGEN



EA



Electronic Arts



ELI



ESTÉE LAUDER COMPANIES



EPD



Enterprise Products Partners LP



APOLLO



AMD



GOOGL



SNAP



Snap Inc.



CMG



CHIPOTLE



ENPH



ENPHASE



AMGN



AMGEN



EA



Electronic Arts



LUMN



LUMEN



JNPR



JUNIPER



PRU



Prudential



Wednesday

Before Open

After Close

UBER



DIS



NVO



novo nordisk



equinor



TOYOTA



BSX



Boston Scientific



SWR



Stanley Black & Decker



CDW



CDW



JCI



Johnson Controls



AURORA



QCOM



F



ARM



arm



SYM



SYMBOTIC



AMSC



ams



VIKING



ONLY



PI



IMPINJ



MET



MeLife



ALGN



align



Thursday

Before Open

After Close

LLY



RBLX



PTON



PELOTON



COP



ConocoPhillips



HERSHEY



TPR



tapestry



PM



OWL



BLUE OWL



BMY



Bristol Myers Squibb



BCE



BCE



AMZN



ELF



NET



CLOUDFLARE



FTNT



FORTINET



PINS



PINTEREST



MCCHIP



MICROCHIP



POWL



POWELL



VCTR



Victory Capital



T2



T2



Friday

Before Open

COC



PAIN



FLO



Flowers



NWL



newell



BYRN



byrna



CBOE



Cboe



EA



GRAFTECH



FTV



FORTIVE



KIM



KIMCO



http://eps.sh/cal

© 2025 Earnings Whispers